

**ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ХУРЛЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 06 дугаар сарын 12

№08

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 1-203 тоот өрөөнд 10:00 цагаас 87 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдан явуулав.

Хуралд: Дарга Н.Эрдэнэхүү, нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа, гишүүн Д.Оюунцэцэг, М.Оюунчимэг, Б.Аюурзана, Б.Оюунтунгалаг, Д.Биндиряа, Л.Амартүвшин, Б.Мөнхцэнгэл, А.Болормаа, Я.Батцэцэг, Ш.Цоож, М.Дэлгэрмаа, Ц.Энхтуул, Г.Батцэцэг, Д.Ариунболор, Г.Ариунтөгс нар оролцов.

Хэлэлцсэн асуудал:

1. Геологи уул, уурхайн сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц
 - ХДХ-ны нарийн бичгийн дарга П.Эрдэнэчимэг
2. Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц
 - СЧА-ны дарга Г.Батцэцэг
3. Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийсэн багийн ажлын үр дүн, дүгнэлт
 - ХЕХ-ны гишүүн М.Оюунчимэг
4. Механик тээврийн сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц
 - СЧА-ны дарга М.Дэлгэрнасан
5. Барилга, архитектурын сургуулийн хөтөлбөр боловсруулах үйл явц
 - СЧА-ны дарга М.Сугар
6. Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийсэн багийн ажлын үр дүн, дүгнэлт
 - ХЕХ-ны гишүүн Д.Ариунболор
7. Гадаад хэлний сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц
 - СЧА-ны дарга А.Болормаа
8. Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийсэн багийн ажлын үр дүн, дүгнэлт
 - ХЕХ-ны гишүүн Я.Батцэцэг
9. Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц
 - СЧА-ны дарга Д.Ганбаатар
10. Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийсэн багийн ажлын үр дүн, дүгнэлт
 - ХЕХ-ны гишүүн П.Ууганбаяр
11. Ахисан түвшний хөтөлбөрийн нэгдсэн танилцуулга
 - АХТА-ны ахлах мэргэжилтэн Д.Батдорж

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

№	Хэлэлцүүлсэн асуудал	Санал, зөвлөмж	ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:
1.	Геологи уул, уурхайн сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцын танилцуулга	<ul style="list-style-type: none"> - Зарим хөтөлбөрийг цөм хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэн дахин төлөвлөх (Уул уурхайн геотехник, Уул уурхайн ашиглалтын технологи /3+2/ гэх мэт); - Сургалтын хөтөлбөрт олгох мэргэжлийн зэргийг зөв төлөвлөх; - Техникийн болон механик алдаа нилээд байгааг засах (үг үсгийн алдаа, нийт кредитийн нийлбэр алдаатай тооцсон, санал болгох төлөвлөгөөнд сонгон кредит дутуу төлөвлөсөн, найруулгын алдаатай, сургалтын хөтөлбөр боловсруулах жишиг загварын бичиглэлийг шууд хуулсан байгааг анхаарах); - Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг дахин нягтлах (багц цагийн хэмжээг үндэслэлгүй өөрчилсөн, сурах бичгийг шинэчлээгүй, агуулга шинэчлээгүй, хичээлийн кодны зарчим баримтлах, багц цагийн задаргааг нягтлах, агуулгын давхардал үүсгэхгүй байхад анхаарах); - Суралцахуйн үр дүнгүүдийн хамаарлыг тодорхойлох; - Хичээлээр олгох ур чадварууд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй хэрхэн яаж холбогдож байгааг зөв тодорхойлох; - Хичээлийн хөтөлбөрүүдийг ижил нэг загварт оруулах (ШУТИС-д мөрдөх жишиг загварын хүрээнд); 	<p>ГУУС-ийн бакалаврын 18 хөтөлбөрийг ХЕХ-ны гишүүдийн саналыг тусган, сайжруулалт хийн, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд эцэслэн хэлэлцүүлэхийг (93%) дэмжлээ.</p>
2.	Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцын танилцуулга	<ul style="list-style-type: none"> - Зарим хөтөлбөрийг цөм хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэн дахин төлөвлөх (Хэрэглээний физик, Химийн инженерчлэл гэх мэт); - Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн ба боловсролын зорилтуудын хоорондын хамаарлыг дахин нягтлах (Хүрээлэн буй орчны иженер /2+2/); - Хөтөлбөрийн ангилал зөв тодорхойлох (цөм хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэх); - Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг дахин нягтлах (сурах бичгийг шинэчлэх, агуулга шинэчлээгүй, хичээлийн кодны зарчим баримтлах, багц цагийн задаргааг нягтлах); - Хичээлийн хөтөлбөрүүдийг ижил нэг загварт оруулах (ШУТИС-д мөрдөх жишиг загварын хүрээнд); 	<p>ХШУС-ийн бакалаврын 9 хөтөлбөрийг ХЕХ-ны гишүүдийн саналыг тусган, сайжруулалт хийн, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд эцэслэн хэлэлцүүлэхийг (90%) дэмжлээ.</p>

		<ul style="list-style-type: none"> - Техникийн болон механик алдаа байгааг засах (найруулгын болон үг үсгийн алдаа, нийт кредитийн нийлбэр алдсан, сургалтын төлөвлөгөөнд тусгасан хичээлийн код бичигдээгүй, хуучин кодоор бичигдсэн, санал болгох төлөвлөгөөг дахин нягтлах, төгсөлтийн ажилтай хамт судлах хичээлийг зөв төлөвлөх); - Хичээлийн хөтөлбөрийг хариуцах салбарыг зөв тодорхойлох (Материал судлал, инженерчлэл) - STEEP, SWOT анализыг хийхдээ гадаад нөлөөллийг зөв, дэлгэрэнгүй тодорхойлох; - Хөтөлбөрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг дутуу гаргасан (Статистик); 	
3.	Механик тээврийн сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцын танилцуулга	<ul style="list-style-type: none"> - Зарим хөтөлбөрийг цөм хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэн дахин төлөвлөх; (Нисэх техникийн механик, авионик хөтөлбөрүүдийг сайжруулах шаардлагатай) - Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн ба боловсролын зорилтуудын хоорондын хамаарлыг дахин нягтлах - Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг дахин нягтлах (сурах бичгийг шинэчлэх 1975 сурах бичиг тавьсан байна. хичээлийн кодны зарчим баримтлах, багц цагийн задаргааг нягтлах, МХТС-ийн хичээлийн хөтөлбөртэй агуулгын давхардал үүсэх эсэхэд анализ хийх); - STEEP, SWOT анализ дутуу хийсэн; - Хөтөлбөрт олгох зэргийг тодорхой тусгах; - Техникийн болон механик алдаа байгааг засах (найруулгын болон үг, үсгийн алдаа, санал болгох төлөвлөгөөг дахин нягтлах, өмнөх холбоо хичээлийг нэг улиралд төлөвлөсөн, хичээлийн код буруу бичсэн, судлах хичээл дутуу бичигдсэн); - Багц цагийн харьцааг хангаагүй; - МХТС, ГУУС, БАТС-тай хичээлийн хөтөлбөрийн агуулгын давхардал болон ахисан түвшний сургалтын хөтөлбөрийн уялдааг хангах байдлаар хамтран ажиллах; 	<p>МехТС-ийн бакалаврын 16 хөтөлбөрийг ХЕХ-ны гишүүдийн саналыг тусган, сайжруулалт хийн, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд эцэслэн хэлэлцүүлэхийг (90%) дэмжлээ.</p> <p>Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 071505 Мехатроник, 071513 Гагнуурын технологи хөтөлбөрүүдийг ХЕХ-ны хурлаар дэмжин, УМИ-д хүсэлт хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>
4.	Барилга, архитектурын сургуулийн хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> - Зарим хөтөлбөрийг цөм хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэн дахин төлөвлөх; (Барилгын инженерчлэл, Усны нөөц, усжуулалт, Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи) 	БАС-ийн бакалаврын 10 хөтөлбөрийг ХЕХ-ны гишүүдийн саналыг тусган, сайжруулалт хийн,

	<p>боловсруулах үйл явцын танилцуулга</p>	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн боловсруулалт дутуу хийсэн (Усны барилга байгууламж); - Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хүрсэн түвшингийн ГҮ-ийг тодорхойлох; - Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг сайжруулах шаардлагатай; (сурах бичгийг шинэчлэх) - STEEP, SWOT шинжилгээг дүгнэж бичих(Архитекур); - Техникийн болон механик алдаа байгааг засах (найруулгын болон үг үсгийн алдаа, санал болгох төлөвлөгөөг дахин нягтлах, хичээлийн код буруу бичсэн, судлах хичээл дутуу бичигдсэн); - Төгсөгчийн чадамжийн хэв шинжүүд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийн хоорондын хамаарал гаргах; - ЭХС, ГУУС, МехТС-ийн хичээлийн хөтөлбөрийн агуулгын давхардал, сургалтын хөтөлбөр хоорондын уялдааг хангах чиглэлд хамтарч ажиллах; 	<p>ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд эцэслэн хэлэлцүүлэхийг (100%) дэмжлээ.</p>
5.	<p>Гадаад хэлний сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцын танилцуулга</p>	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн зорилгыг зөв тодорхойлох; - Цөм хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэх; (Нийгмийн ухааны хичээл ороогүй, гадаад хэлний онцлогоор гаргасан сургалтын төлөвлөгөөний багц цагийг ялгаатай тодорхойлсон) - Ерөнхий суурь хичээлийн харьцааг залруулах; (солонгос хэл) - Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг сайжруулах шаардлагатай;(бичиглэл дутуу, багц цагийн задаргааг засах) - STEEP, SWOT шинжилгээ хийсэн арга зүйг сайжруулах; - Сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын уялдаа холбоог зөв гаргах; (Flowchart) - Техникийн болон механик алдаа байгааг засах (найруулгын болон үг үсгийн алдаа, хичээлийн кодлолтын зарчим баримтлах, судлах хичээл дутуу бичигдсэн); 	<p>ГХС-ийн бакалаврын Гадаад хэлний орчуулга хөтөлбөрийг (5 хэлний чиглэл) ХЕХ-ны гишүүдийн саналыг тусган, сайжруулалт хийн, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд эцэслэн хэлэлцүүлэхийг (100%) дэмжлээ.</p>
6.	<p>Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн сургалтын хөтөлбөр</p>	<ul style="list-style-type: none"> - Цөм хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэх; (Сэтгэл судлал, Математик, байгалийн ухааны чиглэлийн мэргэжлийн суурь хичээл тусгах, ерөнхий суурийн сонгон суралцах дутуу гэх мэт) - Багц цагийн харьцааг баримтлах; 	<p>БуХС-ийн бакалаврын 13 хөтөлбөрийг ХЕХ-ны гишүүдийн саналыг тусган, сайжруулалт хийн, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд эцэслэн</p>

	боловсруулах үйл явцын танилцуулга	<p>- Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг сайжруулах шаардлагатай; (бичиглэл дутуу, сурах бичгийг сайжруулах, хичээлийн кодны зарчим баримтлах)</p> <p>- Сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын уялдаа холбоос зөв гаргах; (Flowchart нэг хичээлийг хэт олон өмнөх холбоо болгосон)</p> <p>- Техникийн болон механик алдаа байгааг засах (хөтөлбөрийн нэр, кредитийн нийлбэр алдаатай);</p>	<p>хэлэлцүүлэхийг (100%) дэмжлээ.</p> <p>Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 041601 Худалдаа, 048802 Бизнес шинжлэл загварчлал хөтөлбөрүүдийг ЭЗ-д танилцуулах эсэхийг СБХА-д ярилцаж шийдвэрлэх.</p>
7.	Ахисан түвшний хөтөлбөрийн нэгдсэн танилцуулга	<p>Хөтөлбөр боловсруулах зарчим дээр дахин сайжруулалт хийх; (БШУ-ы Сайдын 2021 оны А/348 тушаалаар батлагдсан журамтай уялдуулах)</p> <p>Хичээлийн хөтөлбөрийн багц цагийн агуулгыг багасгасан дээр дахин анализ хийж, үр ашгийн тооцоо хийх;</p> <p>Хөтөлбөрийн ангилалд байгалийн ухаан чиглэл нэмэх; (ГУУС-ийн зарим хөтөлбөрийн чиглэл тодорхойгүй)</p> <p>Сургалтын төлөвлөгөөг хаана, хэн батлахыг тодруулах;</p>	<p>Магистрын 119, докторын 59 хөтөлбөрийг ХЕХ-ны санал зөвлөмжийг тусган сайжруулж, Эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэхийг (100%) дэмжлээ.</p> <p>Ахисан түвшний хөтөлбөрүүдийг ХЕХ-д ахисан түвшний хөтөлбөр хариуцахаар өргөтгөн орсон гишүүд, АХТА-тай хамтран ажиллаж сайжруулалт хийн, VI сард багтаан ээлжит бус хурал зарлан дахин хэлэлцүүлэхийг АТХА-д даалгав.</p>

Танилцсан:



Н.Эрдэнэхүү
/ХЕХ-ны дарга/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



М.Эрдэнэтуяа
/ХЕХ-ны нарийн бичгийн дарга/